



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БНА-2023/2/НА-СТА-ТТЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Баянхонгор хот 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер А.Цээням Утас: 70442424 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn</p> <p>Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.	Хараат бус аудиторын дүгнэлт .....	2
	Асуудлыг онцолсон хэсэг .....	3
	Аудитын гол асуудал .....	3
2.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
3.1	Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	13
3.2	Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	14
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4	Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд .....	14
3.4.1	Мөнгөн хөрөнгө .....	15
3.4.2	Авлага .....	15
3.4.3	Бараа материал .....	16
3.4.4	Үндсэн хөрөнгө .....	16
3.4.5	Өр төлбөр .....	17
3.4.6	Засгийн газрын хувь оролцоо .....	18
3.4.7	Орлогын данс .....	18
3.4.8	Зардлын данс .....	19
3.5	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	19
4.	АУДИТЫН ТАЙЛАН .....	21
4.1.	Ерөнхий зүйл .....	21
4.2	Материаллаг байдал .....	22
4.3	Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	22
4.4	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	22
4.5	Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	23
4.7	Аудитын гол асуудал .....	23
5.	Аудитын илрүүлэлт .....	27
5.1	ЗӨВЛӨМЖ .....	27
	Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	28

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ЭМТ	Эрүүл мэндийн төв



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584  
Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2023. 03.24 № 2/119  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жаргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн материаллаг алдааны дүн нь 37,282.5 мянган төгрөг байгаа нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг түвшнээс хэтэрсэн;
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлээгүйгээс Сум хөгжүүлэх сангаас зээл авсан зээлдэгч нарын зээлийн үлдэгдэл, зээлийн эргэн төлөлтийг зөрүүтэй тооцсон, өмнөх оны алдааг нягтлан бодогч давтан гаргасан, тайланг буруу илэрхийлсэн байна.

Дээрх зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь “санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах” заалт болон Оршин байх,

005020484

Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Жаргалант сумын 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний биелэлтийг 7 зорилтын хүрээнд 70 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлийг 80 хувьтай тайлагнасан байна.

Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

## **2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

### **2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан (мянган төгрөгөөр)**

<b>Код</b>	<b>Үзүүлэлт</b>	<b>Эхний үлдэгдэл</b>	<b>Эцсийн үлдэгдэл</b>
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,226,745.12</b>	<b>671,612.42</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>265,428.61</b>	<b>383,643.82</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>265,428.61</b>	<b>383,643.82</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>265,428.61</b>	<b>383,643.82</b>
31211	Төрийн сангийн харилцах	265,428.61	383,643.82
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>540,628.32</b>	<b>158,534.68</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,135.41	3,500.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	341,280.00	0
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>380.74</b>	<b>5,320.56</b>
33510	Байгууллагаас авах авлага	380.74	5,320.56
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>197,832.17</b>	<b>149,714.12</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>197,832.17</b>	<b>149,714.12</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	197,832.17	149,714.12
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>420,688.19</b>	<b>114,433.92</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>65,338.00</b>	<b>0</b>
35110	Тусгай зориулалттай материал	27,171.64	0
35130	Эм боох материал	38,166.36	0
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	3,500.00	0
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>294,941.71</b>	<b>83,045.44</b>
35410	Бичиг хэргийн материал	8,258.45	1,720.58
35420	Аж ахуйн материал	222,393.35	19,981.94
35430	Сэлбэг хэрэгсэл	2,250.00	0
35440	Түлш, шатах тослох материал	1,526.00	0
35450	Барилгын засварын материал	23,155.90	390.80
35460	Хүнсний материал	2,934.28	0
35470	Бусад хангамжийн материал	34,423.73	60,952.12
35600	Мал амьтад	56,908.48	31,388.48
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	<b>0</b>	<b>15,000.00</b>
36100	Барааны нөөц	0	15,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,563,816.98</b>	<b>1,319,318.79</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>5,563,816.98</b>	<b>1,319,318.79</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>5,415,847.78</b>	<b>1,216,506.79</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,447,030.37	808,498.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	-805,031.52	-164,501.18
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,470.80	226,610.80
39204	Хуримтлагдсан элэгдэл	-130,362.01	-147,780.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	809,823.51	272,597.86
39206	Хуримтлагдсан элэгдэл	-572,445.59	-165,515.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	259,431.92	124,365.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	-179,859.76	-49,699.75
39209	Зам, гүүрийн байгууламж	194,620.00	194,620.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-84,959.00	-94,357.25
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,800.00	0
39214	Бусад үндсэн хөрөнгө	403,655.53	451,746.13
39215	Хуримтлагдсан элэгдэл	-212,133.36	-240,077.42
39217	Ном	59,806.88	0
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>147,969.21</b>	<b>102,812.00</b>
39301	Програм хангамж	2,915.00	200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,767.79	-200.00
39303	Бусад биет бус хөрөнгө	146,822.00	102,812.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>6,790,562.10</b>	<b>1,990,931.22</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>45,667.79</b>	<b>63.23</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>45,667.79</b>	<b>63.23</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>45,667.79</b>	<b>63.23</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	788.05	0

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>44,879.75</b>	<b>63.23</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	43,410.69	63.23
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,469.05	0
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,744,894.31</b>	<b>1,990,867.99</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>6,744,894.31</b>	<b>1,990,867.99</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,856,356.15	547,324.88
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,856,356.15	547,324.88
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>834,077.72</b>	<b>1,351,270.82</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	834,077.72	5,808,478.52
51220	Тайлант үеийн үр дүн		-4,457,207.69
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,054,460.44	92,272.28
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>6,790,562.10</b>	<b>1,990,931.22</b>

**Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>4,570,251.10</b>	<b>1,511,197.58</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>261,384.94</b>	<b>434,836.52</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>79,584.03</b>	<b>209,087.48</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>79,584.03</b>	<b>209,087.48</b>
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0	153,123.22
110002	Үйл ажиллагааны орлого	22,038.76	18,683.10
110003	Хөрөнгийн орлого	47,287.03	35,405.56
110004	Хөрөнгө борлуулсны орлого	10,258.24	1,875.60
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>6,600.00</b>	<b>57,696.51</b>
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0	1,006.11
113002	Бууны албан татвар	6,600.00	8,040.00
113004	Малд ногдуулах албан татвар	0	48,650.40
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>175,200.91</b>	<b>168,052.54</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>9,899.29</b>	<b>11,714.36</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,657.62	7,783.33
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	394.50	286.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7,847.17	3,645.03
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>1,137.22</b>	<b>2,311.31</b>
118101	Газрын төлбөр	1,137.22	2,311.31
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>164,164.40</b>	<b>154,026.86</b>
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	164,164.40	154,026.86
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>260,538.08</b>	<b>293,224.38</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>260,538.08</b>	<b>293,224.38</b>
120003	Торгуулийн орлого	7,313.40	19,339.50
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>31,926.93</b>	<b>11,651.16</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,060.63	5,098.51
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,866.30	6,552.65
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	125,439.70	214,967.09
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	95,858.06	47,266.63
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,048,328.08</b>	<b>783,136.68</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,769,105.01</b>	<b>4,709.98</b>
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,294.91	4,709.98
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,744,810.10	0

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>687,234.87</b>	<b>24,919.09</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,394.55	24,919.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,455.31	0
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	512,385.00	0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,566,603.34</b>	<b>753,507.60</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	808,472.24	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	656,643.90	555,685.10
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	101,487.20	197,822.50
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>25,384.87</b>	<b>0</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,384.87	0
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>4,135,968.88</b>	<b>1,289,898.95</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,135,968.88</b>	<b>1,289,898.95</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,092,346.00</b>	<b>924,528.05</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,644,016.12</b>	<b>280,414.62</b>
210101	Үндсэн цалин	1,390,514.32	212,707.74
210102	Нэмэгдэл	127,367.96	40,899.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,525.00	0
210104	Урамшуулал	120,608.84	24,167.19
210105	Гэрээт ажлын хөлс	0	2,640.47
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>215,215.41</b>	<b>36,011.75</b>
210201	Тэтгэврийн даатгал	152,032.33	24,404.40
210202	Тэтгэмжийн даатгал	16,121.89	2,790.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	13,095.21	2,079.78
210204	Ажилгүйдлийн даатгал	3,140.24	684.93
210205	Эрүүл мэндийн даатгал	30,825.74	6,052.08
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>259,915.16</b>	<b>54,792.49</b>
210301	Гэрэл, цахилгаан	16,074.51	4,850.49
210302	Түлш, халаалт	243,192.15	49,942.00
210303	Цэвэр, бохир ус	648.50	0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>144,135.15</b>	<b>95,883.72</b>
210401	Бичиг хэрэг	13,206.24	5,628.21
210402	Тээвэр, шатахуун	66,138.89	46,613.83
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,952.70	4,115.60
210404	Ном, хэвлэл	839.72	1,790.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	481.26	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	41,189.13	643.00
210408	Бараа материал акталсны зардал	6,587.22	33,592.19
210409	Бараа материал шилжүүлсний зардал	8,740.00	3,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>186,466.13</b>	<b>0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	128,294.58	0
210502	Хоол, хүнс	57,780.20	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	391.35	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>13,057.11</b>	<b>3,466.40</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	629.00
210604	Урсгал засвар	13,057.11	2,837.40

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,842.00</b>	<b>8,156.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,842.00	8,156.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>288,997.24</b>	<b>240,843.44</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	281,873.74	237,321.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800.00	500.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18.00	218.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	40.00	240.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,265.50	564.00
210807	Газрын төлбөр	0	1,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>334,701.68</b>	<b>204,959.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	70,579.45	70,881.77
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,134.50	5,648.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	262,987.73	128,429.05
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,043,622.87</b>	<b>365,370.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>156,148.44</b>	<b>30,900.20</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,182.03	17,966.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,994.24	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	57,760.61	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,211.56	12,934.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>843,020.09</b>	<b>334,470.70</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	808,472.24	334,470.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,294.91	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,252.94	0
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,454.34</b>	<b>0</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,454.34	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>434,282.22</b>	<b>221,298.63</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,911.67</b>	<b>4,678,506.32</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	9,911.67	0
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0	4,369,243.93
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0	309,262.39
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>424,370.56</b>	<b>-4,457,207.69</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан (мянган төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,057,166.95	1,313,918.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	261,384.94	434,836.52
110	Орлогын албан татвар	79,584.03	209,087.48
1100	Хувь хүний орлогын албан татвар	79,584.03	209,087.48
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	0	153,123.22
110002	Үйл ажиллагааны орлого	22,038.76	18,683.10
110003	Хөрөнгийн орлого	47,287.03	35,405.56
110004	Хөрөнгө борлуулсны орлого	10,258.24	1,875.60
113	Хөрөнгийн албан татвар	6,600.00	57,696.51
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	0	1,006.11
113002	Бууны албан татвар	6,600.00	8,040.00
113004	Малд ногдуулах албан татвар	0	48,650.40
118	Бусад татвар, төлбөр, хураамж	175,200.91	168,052.54
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	9,899.29	11,714.36
118001	Улсын тэмдэгтийн хураамж	1,657.62	7,783.33
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	394.50	286.00
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7,847.17	3,645.03
1181	Газрын төлбөр	1,137.22	2,311.31
118101	Газрын төлбөр	1,137.22	2,311.31
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	164,164.40	154,026.86
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	164,164.40	154,026.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	88,733.94	93,304.18
120	Нийтлэг татварын бус орлого	88,733.94	93,304.18
120003	Торгуулийн орлого	7,313.40	19,339.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	81,420.54	73,964.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	52,554.24	69,216.56
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,866.30	4,748.12
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,707,048.08	785,778.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,769,105.01	4,709.98
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,294.91	4,709.98
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,744,810.10	0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	345,954.87	27,560.62
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	147,394.55	24,919.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	27,455.31	2,641.53

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	171,105.00	0
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,566,603.34</b>	<b>753,507.60</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	808,472.24	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	656,643.90	555,685.10
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	101,487.20	197,822.50
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>25,384.87</b>	<b>0</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,384.87	0
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,731,046.80</b>	<b>960,316.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,731,046.80</b>	<b>960,316.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,687,423.93</b>	<b>918,750.25</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,644,760.56</b>	<b>331,210.29</b>
210101	Үндсэн цалин	1,252,688.79	234,355.99
210102	Нэмэгдэл	278,278.73	37,981.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,525.00	0
210104	Урамшуулал	108,268.04	4,859.33
210105	Гэрээт ажлын хөлс	0	54,013.41
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>214,256.11</b>	<b>39,737.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	153,986.34	26,661.90
210202	Тэтгэмжийн даатгал	15,027.28	3,056.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,108.38	2,778.06
210204	Ажилгүйдлийн даатгал	3,022.80	650.97
210205	Эрүүл мэндийн даатгал	30,111.31	6,589.79
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>259,011.26</b>	<b>324,220.13</b>
210301	Гэрэл, цахилгаан	17,610.51	23,288.83
210302	Түлш, халаалт	240,752.25	299,261.30
210303	Цэвэр, бохир ус	648.50	1,670.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>67,426.99</b>	<b>32,592.96</b>
210401	Бичиг хэрэг	7,221.55	4,849.96
210402	Тээвэр, шатахуун	44,297.49	21,236.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,862.58	4,115.60
210404	Ном, хэвлэл	1,763.92	1,790.90
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,946.86	0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,334.60	600.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>86,645.72</b>	<b>0</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,336.10	0
210502	Хоол, хүнс	41,545.47	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	15,764.15	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>19,814.71</b>	<b>23,699.10</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	642.60	1,503.10
210604	Урсгал засвар	19,172.11	22,196.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,527.00</b>	<b>8,156.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,527.00	8,156.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>262,500.70</b>	<b>57,955.01</b>

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	255,185.90	54,433.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800.00	500.00
210803	Даатгалын үйлчилгээ	0	400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	18.00	218.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40.00	240.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,456.80	564.00
210807	Газрын төлбөр	0	1,300.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>127,480.87</b>	<b>101,179.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	122,178.82	96,636.95
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,302.05	4,542.80
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,043,622.87</b>	<b>41,565.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>156,148.44</b>	<b>31,535.20</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	15,182.03	17,966.20
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	67,994.24	0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	57,760.61	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	15,211.56	13,569.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>843,020.09</b>	<b>10,030.55</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	808,472.24	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,294.91	4,709.98
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,252.94	5,320.56
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>44,454.34</b>	<b>0</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	44,454.34	0
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>326,120.15</b>	<b>353,602.90</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>196,683.31</b>	<b>235,387.70</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>196,683.31</b>	<b>235,387.70</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>196,683.31</b>	<b>235,387.70</b>
220001	Барилга байгууламж	146,395.00	197,180.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	50,288.31	38,207.70
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-196,683.31</b>	<b>-235,387.70</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>129,436.84</b>	<b>118,215.21</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	135,991.77	265,428.61
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	265,428.61	383,643.82

**2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,251,076.55	3,696,098.83	613,690.28	5,560,865.65
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	605,279.61	358,361.61	-203,983.11	759,658.10
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,856,356.15	4,054,460.44	409,707.17	6,320,523.76
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	424,370.56	424,370.56
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,856,356.15	4,054,460.44	834,077.72	6,744,894.31
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,856,356.15	4,054,460.44	834,077.72	6,744,894.31
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,309,031.27	-3,962,188.15	4,974,400.79	-296,818.63
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	547,324.88	92,272.28	5,808,478.52	6,448,075.68
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	-4,457,207.69	-4,457,207.69
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	547,324.88	92,272.28	1,351,270.82	1,990,867.99

**Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,465,917.00</b>	<b>1,163,433.10</b>	<b>302,483.90</b>	<b>79.37</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,199,377.50</b>	<b>966,253.10</b>	<b>233,124.40</b>	<b>80.56</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,167,811.30</b>	<b>934,717.90</b>	<b>233,093.40</b>	<b>80.04</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>354,257.50</b>	<b>331,210.29</b>	<b>23,047.21</b>	<b>93.49</b>
210101	Үндсэн цалин	242,775.80	234,355.99	8,419.81	96.53
210102	Нэмэгдэл	50,991.50	37,981.57	13,009.93	74.49
210104	Урамшуулал	4,898.80	4,859.33	39.48	99.19
210105	Гэрээт ажлын хөлс	55,591.40	54,013.41	1,577.99	97.16
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>44,560.20</b>	<b>39,737.01</b>	<b>4,823.19</b>	<b>89.18</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,791.00	26,661.90	3,129.10	89.50
210202	Тэтгэмжийн даатгал	3,097.80	3,056.29	41.51	98.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,546.60	2,778.06	768.54	78.33

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210204	Ажилгүйдлийн даатгал	739.30	650.97	88.33	88.05
210205	Эрүүл мэндийн даатгал	7,385.50	6,589.79	795.71	89.23
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>328,422.30</b>	<b>324,220.13</b>	<b>4,202.17</b>	<b>98.72</b>
210301	Гэрэл, цахилгаан	26,696.50	23,288.83	3,407.67	87.24
210302	Түлш, халаалт	299,855.80	299,261.30	594.50	99.80
210303	Цэвэр, бохир ус	1,870.00	1,670.00	200.00	89.30
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>33,716.30</b>	<b>32,592.96</b>	<b>1,123.34</b>	<b>96.67</b>
210401	Бичиг хэрэг	4,925.90	4,849.96	75.94	98.46
210402	Тээвэр, шатахуун	21,691.60	21,236.50	455.10	97.90
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,698.80	4,115.60	583.20	87.59
210404	Ном, хэвлэл	1,800.00	1,790.90	9.10	99.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600.00	600.00	0.00	100.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>44,900.00</b>	<b>44,659.00</b>	<b>241.00</b>	<b>99.46</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,700.00	22,463.00	237.00	98.96
210604	Урсгал засвар	22,200.00	22,196.00	4.00	99.98
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>8,552.00</b>	<b>8,156.00</b>	<b>396.00</b>	<b>95.37</b>
210702	Дотоод албан томилолт	8,552.00	8,156.00	396.00	95.37
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>55,167.00</b>	<b>50,879.76</b>	<b>4,287.24</b>	<b>92.23</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,645.00	47,357.76	4,287.24	91.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.00	500.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	400.00	400.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	218.00	218.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	240.00	240.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	564.00	564.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	1,300.00	1,300.00	0.00	100.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.00	300.00	0.00	100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>298,236.00</b>	<b>103,262.75</b>	<b>194,973.25</b>	<b>34.62</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	292,636.00	98,719.95	193,916.05	33.73
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,600.00	4,542.80	1,057.20	81.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>31,566.20</b>	<b>31,535.20</b>	<b>31.00</b>	<b>99.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>31,566.20</b>	<b>31,535.20</b>	<b>31.00</b>	<b>99.90</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,966.20	17,966.20	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	13,600.00	13,569.00	31.00	99.77
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>266,539.50</b>	<b>197,180.00</b>	<b>69,359.50</b>	<b>73.98</b>
220001	Барилга байгууламж	266,539.50	197,180.00	69,359.50	73.98
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,465,917.00</b>	<b>1,260,348.28</b>	<b>205,568.72</b>	<b>85.98</b>
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,024,120.90</b>	<b>1,186,383.60</b>	<b>-162,262.70</b>	<b>115.84</b>

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

320001	Орон нутгийн төсвөөс	1,024,120.90	988,561.10	35,559.80	96.53
35	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>242,879.50</b>	<b>73,964.68</b>	<b>168,914.82</b>	<b>30.45</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,963.60	69,216.56	83,747.04	45.25
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,405.00	4,748.12	15,656.88	23.27

**Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан (мянган төгрөгөөр)**

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>27,560.62</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>27,560.62</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>22,240.05</b>
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,240.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,240.05
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>5,320.56</b>
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,320.56</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,320.56
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>27,560.62</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>27,560.62</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,919.09
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,641.53

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

**3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Жаргалант сум нь “Мэдлэг, чадварт суурилсан мэргэшсэн захиргааны байгууллага болох” алсын харааг тодорхойлж, “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх” эрхэм зорилготой ажилласан байна.

Төрийн албыг ард иргэдэд хүргэхэд дараах эрхэмлэх үндсэн зарчмыг баримталдаг байна. Үүнд:

- Хууль дээдлэх, шударга байх зарчим - Сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа нь аливаа улс төр, үзэл суртлаас ангид байж, гагцхүү Монгол Улсын хууль тогтоомжийг дээдэлж, иргэдийн эрх ашигт нийцсэн байна.
- Иргэдэд үйлчлэх, шуурхай байх зарчим – Бодит, цаг үеэ олсон, үнэн зөв мэдээлэл, оновчтой бодлого, чиглэлээр иргэдэд үйлчилж, төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэх нөхцөлөөр хангаж ажиллана.
- Ил тод, нээлттэй байх зарчим – Сумын ЗДТГ-ын үйл ажиллагаа нь иргэдэд ил тод, нээлттэй байж, төрийн үйлчилгээг иргэн бүрд хүргэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.
- Мэргэшсэн, тогтвортой байх зарчим – Чадварлаг, мэргэшсэн төрийн албыг бүрдүүлэн төлөвшүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг ханган, төрийн албанд мерит зарчмыг баримтална.
- Хариуцлага хүлээх зарчим – ЗДТГ нь төрийн үйлчилгээг үзүүлэхдээ Монгол Улсын иргэний өмнө хамтын болон ганцаарчилсан хариуцлагыг хүлээж ажиллана.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Жаргалант сумын төсөвт байгууллагуудын мөрдөж байгаа Баянхонгор аймгийн СТХС-ээс 2021 онд бэлтгэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Жаргалант сумын Засаг даргын харьяа байгууллагууд, тусгай сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хууль хяналтын байгууллагаас хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жаргалант сумын Засаг даргын 2022 санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 1,990,931.2 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 4,799,630.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	265,428.6	383,643.8	118,215.2
Авлага	540,628.3	158,534.7	(382,093.6)
Нөөцийн бараа	-	15,000.0	15,000.0
Бараа материал	420,688.2	114,433.9	(306,254.3)
Үндсэн хөрөнгө	5,563,817.0	1,319,318.8	(4,244,498.2)

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

<b>Нийт хөрөнгө</b>	<b>6,790,562.1</b>	<b>1,990,931.2</b>	(4,799,630.9)
Өр төлбөр	45,667.8	63.2	(45,604.6)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,744,894.3	1,990,868.0	(4,754,026.3)
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>6,790,562.1</b>	<b>1,990,931.2</b>	(4,799,630.9)

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 265,428.6 мянга, эцсийн үлдэгдэл 383,643.8 мянган төгрөг болж 118,215.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
<u>Касст байгаа бэлэн мөнгө</u>				
<u>Банканд байгаа бэлэн мөнгө</u>	265,428.6	383,643.8	118,215.2	100%
Орон нутгийн ерөнхий орлого	188,986.4	210,286.4	21,300.0	54.8%
Орон нутгийн хөгжлийн сан	18,962.2	64,220.8	45,258.6	16.7%
Сум хөгжүүлэх сан	57,480.0	109,136.5	51,656.6	28.4%
<u>Замд яваа мөнгөн хөрөнгө</u>				
<u>Хадгаламж</u>				
<b>Дүн</b>	<b>265,428.6</b>	<b>383,643.8</b>	<b>118,215.2</b>	<b>100%</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 383,643.8 мянган төгрөгийн 51,656.6 мянган төгрөг нь сум хөгжүүлэх сан, 45,258.6 мянган төгрөг нь ОНХС-ийн үлдэгдэл байна.

Төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын данс дахь 210,286.4 мянган төгрөгийн 41,421.4 мянган төгрөг нь төсөвт байгууллагуудын оны эцэст буцааж төвлөрүүлсэн төвлөрүүлэх шилжүүлэг, 168,865.0 мянган төгрөг нь орон нутгийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл байна.

### 3.4.2 Авлага

Оны эхэнд 540,628.3 мянган төгрөгийн авлагатай байсан, 2022 онд авлага 382,093.6 мянган төгрөгөөр буурч оны эцэст 158,534.7 мянган төгрөгийн авлагатай гарчээ.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	1,135.4	3,500.0	2,364.6
Байгууллагаас авах авлага	380.7	5,320.6	4,939.8
Татаас санхүүжилтийн авлага	341,280.0	-	(341,280.0)
Зээлийн авлага	197,832.2	149,714.1	(48,118.1)
<b>Дүн</b>	<b>540,628.3</b>	<b>158,534.7</b>	<b>(382,093.6)</b>

Эх сурвалж: Жаргалант сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тус сумын нийт авлагын 94.4 хувийг Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлага, 3.5 хувийг байгууллагаас авах авлага, 2.2 хувийг ажиллагсадтай холбоотой авлага эзэлж байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Бусад авлага	Зээлийн авлага
1	ЗДТГ	330.74	5,320.56	-	5,320.56	-
2	ИТХ	8.84	3,500.00	3,500.00	-	-
3	ЕБС	439.52	-	-	-	-

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

4	Цэцэрлэг	18.46	-	-	-	-
5	ЭМТ	341,521.60	-	-	-	-
6	Соёлын төв	476.90	-	-	-	-
7	СХС	197,832.17	149,714.12	-	-	149,714.12
<b>ДҮН</b>		<b>540,628.23</b>	<b>158,534.68</b>	<b>3,500.00</b>	<b>5,320.56</b>	<b>149,714.12</b>
Дүнд эзлэх хувь			100	2.2	3.4	94.4

Эх сурвалж: Жаргалант сумын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.3 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 420,688.2 мянга, эцсийн үлдэгдэл 129,433.9 мянган төгрөг болж, 329,019.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Тусгай зориулалтын материал	27,171.6	-	(27,171.6)	-
Эм боох материал	38,166.4	-	(38,166.4)	-
Дуусаагүй үйлдвэрлэл	3,500.0	-	(3,500.0)	-
Бичиг хэргийн материал	8,258.4	1,720.6	(6,537.9)	1.33
Аж ахуйн материал	222,393.3	19,981.9	(202,411.4)	15.44
Сэлбэг хэрэгсэл	2,250.0	-	(2,250.0)	-
Түлш, шатах тослох материал	1,526.0	-	(1,526.0)	-
Хүнсний материал	2,934.3	-	(2,934.3)	-
Барилгын засварын материал	23,155.9	390.8	(22,765.1)	0.30
Нөөцийн бараа	-	15,000.0	(22,765.1)	11.59
Мал амьтад	56,908.5	31,388.5	(25,520.0)	24.25
Бусад хангамжийн материал	34,423.7	60,952.1	26,528.4	47.09
<b>Дүн</b>	<b>420,688.2</b>	<b>129,433.9</b>	<b>(329,019.4)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл урьд оноос 329,019.4 мянган төгрөг буюу 69.2 хувиар буурсан нь сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан оны эхний үлдэгдлийн 309,262.4 мянган төгрөгийн бараа материалыг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассан нь бараа материал буурах голлох шалтгаан болжээ.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	102,632.2	124,098.4	21,466.1	95.9
2	ИТХ	5,293.5	5,335.5	42.0	4.1
3	ЕБС	140,492.4	-	(140,492.4)	0.0
4	Цэцэрлэг	54,999.1	-	(54,999.1)	0.0
5	ЭМТ	99,580.2	-	(99,580.2)	0.0
6	Соёлын төв	14,190.7	-	(14,190.7)	0.0
7	ОНХС	3,500.0	-	(3,500.0)	0.0
<b>ДҮН</b>		<b>420,688.2</b>	<b>129,433.9</b>	<b>(287,754.3)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 146,646.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, хандиваар 41,187.0 мянган төгрөгийн хөрөнгө авч, 6,079.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн орлогоор бүртгэсэн, үйл ажиллагаанд нийт 138,812.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

### 3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 7,550,376.0 мянга, эцсийн үлдэгдэл 2,181,450.9 мянган төгрөг болж, 5,368,925.1 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга байгууламж, орон сууц	5,447,030.4	808,498.6	(4,638,531.8)
Тээврийн хэрэгсэл	224,470.8	226,610.8	2,140.0
Машин тоног төхөөрөмж	809,823.5	272,597.9	(537,225.6)
Тавилга эд хогшил	259,431.9	124,365.5	(135,066.4)
Номын фонд	59,806.9	-	(59,806.9)
Зам, гүүрний байгууламж	194,620.0	194,620.0	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,800.0	-	(1,800.0)
Бусад үндсэн хөрөнгө	403,655.5	451,746.1	48,090.6
Программ хангамж	2,915.0	200.0	(2,715.0)
Бусад биет бус хөрөнгө	146,822.0	102,812.0	(44,010.0)
<b>Дүн</b>	<b>7,550,376.0</b>	<b>2,181,450.9</b>	<b>(5,368,925.1)</b>

*Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд сумын ЗДТГ нь 13,169.5 мянган төгрөгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 226,300.9 мянган төгрөгийн их засварын барилгын сайжруулалтаар бүртгэсэн ба сумын сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төв, соёлын төвүүд нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан 4,847,479.4 мянган төгрөгийн хөрөнгийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлэн данс бүртгэлээс хассанаас нийт хөрөнгө 4,609,169.4 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
1	ЗДТГ	1,914,151.2	2,164,243.0	250,091.7	99.2%
2	ИТХ	14,124.8	17,207.8	3,083.0	0.8%
3	ЕБС	1,790,957.0		(1,790,957.0)	0.0
4	Цэцэрлэг	413,427.2		(413,427.2)	0.0
5	ЭМТ	1,197,316.9		(1,197,316.9)	0.0
6	Соёлын төв	2,220,398.5		(2,220,398.5)	0.0
	<b>ДҮН</b>	<b>7,550,375.8</b>	<b>2,181,450.8</b>	<b>(5,368,925.0)</b>	<b>100%</b>

*Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 45,667.8 мянга, эцсийн үлдэгдэл 43.2 мянган төгрөг болж 45,604.6 мянган төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 9. Нийт өр төлбөрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	45,667.79	63.23	(45,604.57)	100.00
Ажилчидтай холбогдсон өглөг	788.05	-	(788.05)	-
Байгууллагад төлөх өглөг	43,410.69	63.23	(43,347.47)	100.00
Хувь хүмүүст төлөх өглөг	1,469.05	-	(1,469.05)	-
Урт хугацаат өр төлбөр дүн	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>45,667.79</b>	<b>63.23</b>	<b>(45,604.57)</b>	

*Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Өмнөх оноос өглөг буурсан нь сумын төсөвт байгууллагууд өмнөх оны өглөгийг бүрэн барагдуулсантай холбоотой, сумын ЗДТГ-аас бусад байгууллагууд Төсвийн тухай хуулийг мөрдөж, өглөггүй ажилласан байна.

*Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл байгууллагаар /мянган төгрөгөөр/*

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Үүнээс:		
				Ажиллагсадтай холбоотой	Байгууллагад төлөх өглөг	Бараа үйлчилгээний зардлын өглөг

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

1	ЗДТГ	29.9	63.2		63.20	
2	ЕБС	330.7				
3	Цэцэрлэг	395.8				
4	ЭМТ	44,849.9				
5	Соёлын төв	61.5				
<b>ДҮН</b>		<b>45,667.8</b>	<b>63.2</b>	<b>0.0</b>	<b>63.2</b>	<b>0.0</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 6,744,894.3 мянга, эцсийн үлдэгдэл 1,990,867.9 мянган төгрөг болж, 4,754,026.3 мянган төгрөгөөр төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт /-/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,856,356.15	547,324.88	(1,309,031.27)	27.5
Хуримтлагдсан үр дүн	834,077.73	1,351,270.82	517,193.09	67.9
Өмнөх үеийн үр дүн	834,077.73	5,808,478.51	5,398,771.34	
Тайлант үеийн үр дүн		(4,457,207.69)	(4,881,578.25)	
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,054,460.43	92,272.28	(3,962,188.15)	4.6
<b>Дүн</b>	<b>6,744,894.31</b>	<b>1,990,867.98</b>	<b>(4,754,026.33)</b>	<b>100</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 4,754,026.3 мянган төгрөг болж буурсан нь боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбогдуулан үндсэн хөрөнгө, бараа материалын дансны үлдэгдлийг бүтцийн өөрчлөлтөөр шилжүүлсэнтэй холбоотой байна.

### 3.4.7 Орлогын данс

Сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.20-ны өдрийн 5/11 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 255,270.0 мянга, татварын бус торгуулийн орлогыг 8,000.0 мянган, нийт 263,270.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.17-ны өдрийн 7/06 дугаар тогтоолоор малын тоо толгойн албан татварыг 16,179.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 2022 онд оруулах орлогыг 279,449.4 мянган төгрөгөөр баталжээ.

Хүснэгт 12. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төвлөлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>Нийт орлогын дүн</b>	<b>279,449.4</b>	<b>454,176.0</b>	<b>174,726.6</b>	<b>162%</b>
<b>Татварын орлого</b>	<b>271,449.4</b>	<b>434,836.5</b>	<b>163,387.1</b>	<b>167.5%</b>
<b>Орлогын албан татвар</b>	<b>194,000.0</b>	<b>209,087.5</b>	<b>15,087.5</b>	<b>107.7%</b>
Хувь хүний орлогын албан татвар /СУУТГАН/	115,000.0	153,123.2	38,123.2	133.2%
Хувь хүний орлогын албан татвар /иот/	20,000.0	18,683.1	(1,316.9)	93.4%
Хадгаламжийн хүү	55,000.0	35,405.6	(19,594.4)	64.3%
ҮХЭХ худалдсан борлуулсны албан татвар	4,000.0	1,875.6	(2,124.4)	46.8%
<b>Өмчийн татвар</b>	<b>43,929.4</b>	<b>57,696.5</b>	<b>13,767.1</b>	<b>131.3%</b>
ҮХЭХ-ийн татвар	1,250.0	1,006.1	(243.9)	80.4%
Бууны албан татвар	6,500.0	8,040.0	1,540.0	123.6%
Малын тоо толгойн албан татвар	36,179.4	48,650.4	12,471.0	134.4%
<b>Бусад татвар /төлбөр хураамж/</b>	<b>33,520.0</b>	<b>168,052.5</b>	<b>134,532.5</b>	<b>501.3%</b>
Тэмдэгтийн хураамж	1,500.0	7,783.3	6,283.3	518.8%
Газрын төлбөр	3,300.0	2,311.3	(988.7)	70.0%

ТТАМ ашигласны төлбөр	1,000.0	286.0	(714.0)	28.6%
Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	9,000.0	3,645.0	(5,355.0)	40.5%
Ан агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах барих зөвшөөрлийн хураамж	18,720.0	154,026.9	135,306.9	822.8%
<b>Татварын бус орлого</b>	<b>8,000.0</b>	<b>19,339.5</b>	<b>11,339.5</b>	<b>241.7%</b>
Торгуулийн орлого	8,000.0	19,339.5	11,339.5	241.7%

Эх сурвалж: Татварын орлогын хэлбэлзэл, татварын байцаагчаас ирүүлсэн судалгаа

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 160 хувь буюу 163,387.1 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн, орлогын нэр төрлөөр авч үзвэл цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 36,806.3 мянга, малын тоо толгойн албан татвар 12,471.0 мянга, тэмдэгтийн хураамж 6,283.3 мянга, ан агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамж 135,306.9 мянган төгрөгөөр тус тус давуулан биелүүлсэн байна.

“Ажийн болор” ХХК-аас 4 тэх агнах зөвшөөрөл олгож, 6,510.4 мянган төгрөгийн улсын тэмдэгтийн хураамж төлсөн, 2021 онд төсвийн төлөвлөгөөг сумын ИТХ-аар батлахад мал тооллогын нэгдсэн дүн гараагүй байснаас малын тоо толгойн албан татварыг бага төлөвлөсөн, 2022 онд 8 тоо толгойн шонхор барих гэрээ байгуулан, 124,809.6 мянган төгрөг орсон, сумын цагдаагаас тогтоосон зөрчлийн дүн өндөр байсан зэрэгтэй холбоотой дээрх татварууд төлөвлөснөөс давж биелсэн байна.

Харин хувь хүний орлогын албан татвар 1,316.9 мянга, хадгаламжийн хүүгийн орлого 19,594.4 мянга, газрын төлбөр 988.7 мянга, хог хаягдлын үйлчилгээний хураамж 5,355.0 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 714.0 мянган төгрөгөөр тус тус тасарсан нь орлогын төлөвлөгөөг биелүүлэх талаар арга хэмжээ аваагүй, иргэдийн хадгаламжийн хүү буурсан зэрэгтэй холбоотой байна.

Жаргалант сумын татварын байцаагч сумын татварын гүйцэтгэлийн мэдээг 435,359.8 мянган төгрөг буюу төсвийн төвлөрүүлэн захирагчийн тайлангаас 523.3 мянган төгрөгөөр илүү мэдээлсэн байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор сумын ЗДТГ 1,000.0 мянган төгрөгийн орлого орохоор төлөвлөснөөс 2,570.0 мянган төгрөг, сумын ОНХС-ийн үйл ажиллагааны орлого 4,680.0 мянган, Сум хөгжүүлэх сангаас олгосон зээл, хүүгийн эргэн төлөлтийн орлогоор 152,963.6 мянган төгрөг оруулахаас гүйцэтгэлээр 68,819.6 мянган төгрөг орсон нь ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлага, идэвх санаачилга хангалтгүй байсантай холбоотой байна.

### 3.4.8 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 71806, 72101 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 1,465,917.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,163,433.1 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 642,033.0 мянган төгрөгийг урсгал зардалд, 324,220.1 мянган төгрөгийг тогтмол зардалд, 197,180.0 хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, улсын төсвийн байгууллагын тогтмол зардлыг төлөвлөж хүргүүлсэн аймгийн СТСХ-т хүргүүлсэн ба Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021.12.20-ны өдрийн 5/11 дүгээр тогтоолоор сумын төсвийн нийт зардлыг 1,531,138.6 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын хуралдааны 2021.12.20-ны өдрийн 5/11 дүгээр тогтоолоор анх 1,531,138.6 мянган төгрөгөөр баталсан, анхны төсөвт сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.17-ны өдрийн 7/06 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, 1,465,917.0 мянган төгрөг болгон 65,221.6 мянган төгрөгөөр бууруулан баталж, эх үүсвэрийг дараах байдлаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 13. Жаргалант сумын 2022 оны төсвийн санхүүжүүлэх эх үүсвэр /мянган төгрөгөөр/

Санхүүжих эх үүсвэр	Дүн	Дүнд эзлэх хувь
Орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилт	198,916.60	13.6
Аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	555,685.10	37.9
Сумын орон нутгийн татварын болон татварын бус орлого	279,449.40	19.1
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	258,497.30	17.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	152,963.60	10.4
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих: Үүнээс	20,405.00	1.4
Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,000.00	0
Орон нутгийн хөгжлийн сангийн өвс, тэжээлийн орлого	19,405.00	0
<b>ДҮН</b>	<b>1,465,917.00</b>	<b>100.0</b>

Эх сурвалж. Жаргалант сумын ИТХ-ын хуралдааны 2022 оны 7/06 дугаар тогтоол

Сумын ИТХ-аар баталсан төсөв 1,465,917.0 мянган төгрөг байхад төсвийн төлөвлөлтийн программд 1,465,916.5 мянган төгрөг буюу 0.5 мянган төгрөгөөр зөрүүтэй оруулсан байгаа тул аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн төсвийн мэргэжилтэнд энэ талаар мэдэгдсэн болно.

Сумын ИТХ-ын хуралдааны 2022.06.17-ны өдрийн 7/06 дугаар тогтоолоор төсвийн нийт зарлагыг 1,465,917.0 мянган төгрөг болгон 65,221.6 мянган төгрөгөөр бууруулсан нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 89,408.5 мянга, ОНХС-аас олгох дэмжлэгийг 16,178.9 мянган төгрөгөөр бууруулж, сумын татварын орлогыг 16,179.5 мянга, урьд оны үлдэгдлийг 24,186.4 мянган төгрөгөөр бууруулсантай холбоотой байна.

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг бүрэн авч, орон нутгийн төсвөөс 454,179.0 мянга, орон нутгийн хөгжлийн сангаас олгох санхүүжилт 197,822.5 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 69,216.6 мянга, туслах үйл ажиллагааны орлого 4,748.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, оны эцэст хэмнэгдсэн зардлын 41,421.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 14. Төсвийн гүйцэтгэл байгууллагаар /мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	ОНТ-т төвлөрүүлсэн
1	ЗДТГ	536,612.60	510,879.12	25,733.48	95.2	27,303.48
2	ИТХ	117,858.20	108,450.26	9,407.94	92.0	9,407.94
3	ЕБС	158,604.00	157,381.74	1,222.26	99.2	1,222.26
4	Цэцэрлэг	46,532.00	45,076.04	1,455.96	96.9	1,455.96
5	ЭМТ	41,262.70	40,063.09	1,199.61	97.1	1,199.61
6	Соёлын төв	88,072.00	87,239.85	832.15	99.1	832.15
7	ОНХС	266,539.00	197,180.00	69,359.00	74.0	-
8	СХС	210,436.00	17,163.00	193,273.00	8.2	-
	<b>ДҮН</b>	<b>1,465,916.50</b>	<b>1,163,433.10</b>	<b>302,483.40</b>	<b>79.4</b>	<b>41,421.40</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,163,433.1 мянган төгрөг буюу 79.4 хувьтай байгаа нь ОНХС-аас хэрэгжүүлэн төсөл арга хэмжээг 69,359.0 мянга, Сум хөгжүүлэн сангаас олгохоор төлөвлөсөн зээлийг олгоогүйгээс 193,273.0 мянга, сумын ЗДТГ, ИТХ орон тоо дутуу ажилласнаас цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал хэмнэгдсэн зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Жаргалант сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 26,260.6 мянга, ИТХ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 1,300.0 мянга, нийт 27,560.6 мянган төгрөгийн санхүүжилт орсныг бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулан, ЗДТГ хэмнэгдсэн 5,320.6 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жаргалант сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.05-ны өдөр ирүүлсэн байна.

Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга Д.Мөнхжаргал, 2 дугаар гарын үсгийг сумын санхүүгийн албаны дарга Д.Азжаргал нар зурж хөрөнгийг захиран зарцуулсан байна.

#### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны баталсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Их" гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны баталсан төсөв 1,465,917.0 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,659.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10,994.4 мянган төгрөгөөр тогтоосон, төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023.03.10-ны өдөр сумын Засаг даргаас 1а/36 дугаар албан бичгээр ирүүлсэн, ирүүлсэн албан бичигт Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллаж, дараах үр дүн гарсан гэж тайлагнасан байна. Үүнд:

- Хэмнэлтийн тухай хуультай холбоотой шуудан холбооны зардал, хог хаягдлын зардал хэмнэгдсэн;
- Сумын ЗДТГ, ИТХ орон тоо дутуу ажилласан тул цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, урамшууллын зардал хэмнэгдсэн;
- Тогтмол зардлуудыг гүйцэтгэлээр олгож, хэмнэгдсэн зардлыг төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 15. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	354,257.50	331,210.29	23,047.21
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,560.20	39,737.01	4,823.19
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	328,422.30	324,220.13	4,202.17
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,167.00	50,879.76	4,287.24
<b>ДҮН</b>	<b>782,407.00</b>	<b>746,047.19</b>	<b>36,359.81</b>

Эх сурвалж: Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Жаргалант сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт 2022 оны 6-7 дугаар сард 120.0 мянган төгрөгийн гар утасны төлбөрийг төлсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12.1.1 дэх "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно: гар утасны зардал" гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоосон байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Жаргалант сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 76 мэдээлэл оруулахаас 66 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлж, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Жаргалант сумын харьяаны төсвийн 2 байгууллага, 2 сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлэл дутуу байршуулсан, орхигдуулсан зөрчил илэрч албан шаардлага, зөвлөмж өгсөн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Жаргалант сумын харьяаны төсвийн шууд захирагчийн тайланд төрийн аудитын байгууллагаас завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр аудит хийж, сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын үлдэгдлийн судалгааг үнэн зөв тайлагнах 1 албан шаардлага, зөрчлийг арилгах 3 зөвлөмж өгсөн байна.

Жаргалант сумын Засаг даргын 2022.09.29-ний өдрийн 1а/148 дугаар албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн ба, албан шаардлагын хариуг албан бичгээр гаргаж ирүүлээгүй, 2022 онд сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн судалгааны эхний болон эцсийн үлдэгдлийг зөрүүтэй гаргасан зөрчил давтагдсан тул сумын сум хөгжүүлэх сангийн нягтлан бодогч Д.Доржпагмад хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлж ажиллав.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Байхгүй.

#### **4.7 Аудитын гол асуудал**

Сумын Засаг даргын харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан ба ЭМТ, сургууль, цэцэрлэг, Соёлын байгууллагын орон нутгийн төсвөөс олгосон санхүүжилт, гүйцэтгэл төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэгдсэн байна.

Жаргалант сумын Засаг даргын харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар сумын ОНХС-ийн санхүүгийн тайлангаас бусад тайланд нийт 21,871.3 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад алдааг санхүүгийн тайланд залруулсан байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.



**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2	Жаргалант сумын ОНХС	Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажилд шууд гэрээ байгуулж, гүйцэтгэхдээ сумын Засаг дарга захирамж гаргаагүй байна.	191,860.0	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
3	Жаргалант сумын ОНХС	Сумын ОНХС-ийн хөрөнгөөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан 9 аж ахуйн нэгжид 191,860.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгохдоо и-баримтыг үндэслэн гүйлгээг хийгээгүй атлаа татварыг суутган тооцож, орон нутгийн орлогод төвлөрүүлээгүй байна.	15,461.0	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
4	Жаргалант сумын ОНХС	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 9-12 дугаар сард мэдээллийг байршуулаагүйгээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 67,587.0 мянган төгрөгийн 7 худалдан авалтыг мэдээлээгүй, тайланд онд байгуулсан 13 гэрээ, мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	0	Албан шаардлага өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
<b>ДҮН</b>			<b>207,321.0</b>			
1	Жаргалант сумын СХС	Баянхонгор аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газраас ирүүлсэн Монголбанкны мэдээллийн санд 164,157.6 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байхад санхүүгийн тайлан дахь сум хөгжүүлэх сангаас зээл авсан авлагын үлдэгдэл тус үлдэгдлээс 14,443.5 мянган төгрөгөөр дутуу буюу 149,714.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.	14,443.50	Зөвлөмж өгсөн	Материаллаг	Санхүүгийн аудит
2	Жаргалант сумын СХС	ОНХС-ийн нягтлан бодогч Д.Доржпагма аудитад шаардлагатай баримт материалыг удаа дараа шаардуулсан, сумын ТТЗ-ийн өмнөх оны аудитаар санхүүгийн тайлангийн авлагын эхний, эцсийн үлдэгдлийг зээлдэгч бүрээр гаргасан судалгааг үнэн зөв гаргах албан шаардлага өгсөн байхад зөрчлийг арилгаагүй, оны эцсийн зээлийн авлагыг зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	-	Хариуцлага тооцох	Материаллаг	Санхүүгийн аудит
3	Жаргалант сумын СХС	Сумын Засаг даргын шийдвэргүйгээр гэр интернэтийн зардалд 50.0 мянган төгрөгийг шилжүүлж, санхүүгийн баримтад хоосон нэхэмжлэх хавсаргасан байна.	50.00	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
4	Жаргалант сумын СХС	Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан 13 иргэний 7,008.0 мянган төгрөгийн зээлийг төлөөгүй хугацаа хэтрүүлсэн байхад гэрээний үүргээ зөргсөн иргэдийг хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.	7,008.02	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
5	Жаргалант сумын СХС	Сумын Засаг даргын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 2022 онд олгосон 16,000.0 мянган төгрөгийн шийдвэрийг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
<b>ДҮН</b>			<b>21,501.52</b>			
1	Жаргалант сумын ИТХ	Бараа материалын тайлан үнэн зөв, бүрэн тайлагнаагүйгээс санхүүгийн тайлангаас 6,505.0	6,505.00	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

		мянган төгрөгөөр зөрүүтэй бэлтгэсэн байна.				
2	Жаргалант сумын ИТХ	Тайлант оны 3 дугаар сард төлөөлөгч нарын хоолны зардлаас хувь хүний орлогын албан татварт 90.0 мянган төгрөгийг суутгасан атлаа төсөвт төвлөрүүлээгүй байна.	90.00	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
3	Жаргалант сумын ИТХ	Шилэн дансны 3 бүлэг мэдээллийн 20 нэр төрлийн мэдээллийн хэсэгт 128 мэдээлэл оруулахаас 15 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, 2,004.0 мянган төгрөгийн хөрөнгө захиран зарцуулах 3 тушаал, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш 10,607.0 мянган төгрөгийн 5 гүйлгээ, 6,313.2 мянган төгрөгийн зарлагын 1 гүйлгээг мэдээлээгүй орхигдуулсан байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
4	Жаргалант сумын ИТХ	Жаргалант сумын ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт 2022 оны 6-7 дугаар сард 120.0 мянган төгрөгийн гар утасны төлбөрийг төлсөн байна.	120.00	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой
ДҮН			6,715.00	-	-	-
1	Жаргалант сумын ЗДТГ	Жилийн эцсийн тооллогын баримтын тооцоо бодсон акт хийгээгүй, тоолсон хөрөнгүүдийн дүнг нэгтгээгүй, нэгтгэлийн дүн ойлгомжгүй.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
2	Жаргалант сумын ЗДТГ	Байгууллагын нярав бараа материалын тайланг 7,751.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан, 7,500.0 мянган төгрөгийн бараа материалыг бөөнд дүнгээр тайлагнасан, 40,587.0 мянган төгрөгийн малын өвс, тэжээлийн тайланг бэлтгэж гаргаагүй байна.	55,838.10	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
3	Жаргалант сумын ЗДТГ	Санхүүгийн анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй, зарим төлбөрийн хүсэлтэд нэхэмжлэх, бусад холбогдох материал байхгүй, төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсанд дагалдах баримтуудыг бүрэн тусгаагүй.	5,856.10	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Санхүүгийн аудит
4	Жаргалант сумын ЗДТГ	Нохой устгалд олгосон 1,000.0 мянган төгрөгийн ажлын хөлснөөс хувь хүний орлогын албан татварыг суутгаагүй байна.	110.00	Төлбөрийн акт тогтоосон	Материаллаг	Санхүүгийн аудит
5	Жаргалант сумын ЗДТГ	Шилэн дансны цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого зарлагын гүйлгээний мэдээлэл оруулах хэсгийн орлогод 8 төрлийн 73,396.1 мянга, зарлага хэсэгт 18 төрлийн 155,018.3 мянга, 5,100.0 мянган төгрөгийн 2 тушаал, 26,585.0.0 мянган төгрөгийн 6 гэрээг байршуулаагүй байна.	-	Зөвлөмж өгсөн	Материаллаг бус	Нийцлийн аудит
ДҮН			61,804.20			
18	НИЙТ АЛДАА, ЗӨРЧЛИЙН ДҮН		297,341.72			

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн 4 зөрчилд зөрчлийг арилгах 4 зөвлөмж өгсөн.

### 5.1 ЗӨВЛӨМЖ

#### 1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 319,212.9 мянган төгрөгийн 4 алдаа, 18 зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасныг зөрчсөн, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Засаг дарга Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь заалтыг мөрдөж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсөвт байгууллагуудад дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

2. Илрүүлэлт: Малын тоо толгойн албан татвараар 54,393.8 мянган төгрөгийн татвар оруулахаар байхад 2022 онд татварыг 36,179.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 48,650.4 мянган төгрөгийн татварыг оруулсан байхад сумын татварын байцаагчаас ирүүлсэн татварын хэлтсийн судалгаагаар 83 малчнаас 4,273.6 мянган төгрөгийн татварын авлагатай байна.

Энэ нь Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь “Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн тодорхойлно”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх “Албан татвар төлөгч энэ хуулийн дагуу ногдуулсан албан татварыг тэнцүү хоёр хуваан тухайн жилийн 7 дугаар сарын 15, 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор өөрийн өмчилж байгаа малын тоо толгой тоологдож бүртгэгдсэн сум, дүүргийн төсөвт төлнө” гэсэн заалтыг зөрчин, санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын малын тоо толгойн албан татварын төлөвлөлтийг үнэн зөв тодорхойлж, 2022, 2023 оны татварыг тайлант хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлэх

3. Илрүүлэлт: Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар “СХС-ийн дэлгэрэнгүй бүртгэл, судалгааг зээлдэгч бүрээр үнэн зөв гарган, авлагын үлдэгдлийг баталгаажуулан, зөрчлийг арилгах” албан шаардлагыг өгч, биелэлтийг 2022.04.25-ны өдөр ирүүлэхээр заасан байхад албан шаардлагын хариуг албан бичгээр гаргаж ирүүлээгүй, 2022 онд сум хөгжүүлэх сангаас зээл авсан иргэдийн судалгааны эхний болон эцсийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан зөрчил Сум хөгжүүлэх сангийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дахин давтагдсан байна.

Иймд төрийн аудитын байгууллагаас өгсөн албан шаардлагыг биелүүлээгүй Жаргалант сумын сум хөгжүүлэх сангийн нягтлан бодогч Д.Доржпагмад Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн

албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэснийг үндэслэн хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Өгсөн зөвлөмж: Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулан, хугацаа хэтэрсэн зээлдэгч нарт тавих дотоод хяналтыг сайжруулах

4. Илрүүлэлт: Жаргалант сумын Засаг даргын харьяаны ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-д хийсэн төсвийн шууд захирагчийн тайланд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө захиран зарцуулах шийдвэр, аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг байршуулаагүй орхигдуулсан, хугацаа хоцроож мэдээллийг байршуулсан зөрчил илэрсэнд Төрийн аудитын байгууллагаас зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах албан тушаалтан, байгууллагын дарга нарын ажлын хариуцлагыг сайжруулах

Аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж биелэлтийг нотлох баримтын хамт 2023 оны 06 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Жаргалант сумын Засаг даргын санхүүгийн тайланд нэгтгэгддэг сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт сул байгаагаас 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 319,212.9 мянган төгрөгийн 4 алдаа, 18 зөрчил илэрсэн байна.	1	-					1	-					
Малын тоо толгойн албан татвараар 54,393.8 мянган төгрөгийн татвар оруулахаар байхад 2022 онд татварыг 36,179.4 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 48,650.4 мянган төгрөгийн татварыг оруулсан байхад татварын байцаагчаас ирүүлсэн судалгаагаар 83 малчнаас 4,273.6 мянган төгрөгийн татварын авлагатай байна.	1	4,273.5					1	4,273.5					

**Баянхонгор аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Жаргалант сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлээгүйгээс зөрчил 2022 онд дахин давтагдсан.	1	-					1	-				
Дүн	3	4,273.5	0	-	0	-	3	4,273.5	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Жаргалант сумын Засаг даргын харьяаны ЗДТГ, ИТХ, ОНХС, СХС-д хийсэн төсвийн шууд захирагчийн тайланд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө захиран зарцуулах шийдвэр, аж ахуйн нэгж, иргэнтэй байгуулсан гэрээ, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг байршуулаагүй орхигдуулсан, хугацаа хоцроож мэдээллийг байршуулсан зөрчил илэрсэнд Төрийн аудитын байгууллагаас зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 3 зөвлөмж өгсөн байна.	1	0					1	0
Дүн	1	0	0	0	0	0	1	

---oOo---